

БАТЛАВ
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Ц.ЧОГСОМЖАВ

2024 оны дугаар сарын

УДИРДАМЖ

2024 оны дугаар сарын

Чингис хот

**“ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН СПОРТЫН НААДАМ”-2024
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Нэг . Зорилго

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.2, 8.1.3, Засгийн газрын 2019 оны 153 дугаар тогтоол “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”-ийн 2 дугаар зүйлийн 2.3.1, 4.1.2, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2 дугаар зүйлийн 2.2.3.1 дэх заалтын хэрэгжилтийг тус тус хангах, ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ажлын хүрээнд төрийн албан хаагчдыг биеийн тамир спортоор хичээллүүлэх, эрүүл мэндийг дэмжих, харилцан туршлага судлуулах, ажлын уялдаа холбоог сайжруулах, хамтач эерэг уур амьсгалыг бий болгох, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэхэд оршино.

Хоёр. Зохион байгуулалт

“Төрийн албан хаагчдын спортын наадам”-ыг аймгийн Биеийн тамир, спортын газар, тухайн төрлийн спортын холбоод удирдан 2024 оны 04 дүгээр сарын 04-07-ны өдрүүдэд (ЕБС-ийн амралтаар зохицуулагдана) зохион байгуулах ба ерөнхий зохион байгуулалтад Хэрлэн 1 дүгээр сургууль, Хан Хэнтий цогцолбор сургууль, Тэмүүжин цогцолбор сургууль, Хэрлэн 4 дүгээр сургууль, Хэрлэн 5 дугаар сургууль, Политехник коллежийн захиргаа, спортын төрлүүдийн шүүгчдийн бүрэлдэхүүнд биеийн тамир, эрүүл мэндийн багш нар тус тус оролцоно.

Гурав. Тэмцээний төрөл

- Олс таталт
- Сагсан бөмбөг
- Волейбол
- Дартс

Дөрөв. Тэмцээнд оролцогчид, насны ангилал, хүний тоо

Спортын наадамд Хэрлэн сумаас бусад 17 сум, Бэрх, Гурванбаян тосгон тус тус нэг шигшээ баг (Хэрлэн сум Өлзийт болон Тахилгат тосгон 1 ясли, 10 цэцэглэг, 5 сургууль, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг хамруулж 2 шигшээ баг) агентлаг, байгууллагууд хавсралтад заагдсан хуваарийн дагуу нэг шигшээ баг бүрдүүлж тус тус оролцоно.

Тэмцээнд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө төрийн албанд томилогдсон төрийн албан хаагчид хамрагдана.

Нэг тамирчин 2 хүртэлх спортын төрөлд оролцож болно.

Босоо удирдлагатай байгууллагуудын тухайн суманд ажилладаг төрийн албан хаагчид нь тэмцээнд зөвхөн сумын харьяаллын дагуу багаа төлөөлөн оролцоно.

Багуудын тэмцээнд оролцоход шаардагдах байр, хоол, унаа бусад холбогдох зардлыг тамирчдаа оролцуулж буй тухайн сум, байгууллага хариуцна.

Тэмцээний нээлтийн ажиллагаанд баг тус бүрээс 10 тамирчин жигд өмсгөл, хувцас, багаа илэрхийлэх тугтай жагсана.

Тугийн хэмжээ 120см:80см харьцаатай байх ба тугийн ишний урт 240см байна.

Тэмцээнд (Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт ажиллаж байгаа биеийн тамирын багш, эрүүл мэндийн багш нар) оролцохгүй.

Олс таталт:

Олс таталтын төрөлд 4 эрэгтэй, 4 эмэгтэй 8 хүний бүрэлдэхүүнтэй холимог баг оролцоно. Багийн нийт жин 630 кг хүртэл байна. (багийн баталгаажсан мэдүүлэг дээрх олс таталтын 8 тамирчны жингийн нийлбэр дээд тал нь 630кг 00гр байх ба 630 кг 01гр буюу түүнээс дээш байгаа тохиолдолд тухайн баг жингээр хасагдана)

Тэмцээн хасагдах журмаар явагдах ба эхэлж 2 хожсон баг нь дараагийн шатанд шалгарна.

Эхний таталтад талбай сонголтыг багийн ахлагч нар хийж, 2 дахь таталтад 2 баг байр солино.

Багууд 2 удаа татаж хожлын харьцаа 1:1 болсон тохиолдолд шийдвэрлэх 3 дахь таталтыг гүйцэтгэнэ.

Таталт гүйцэтгэх тамирчдын байрлалаа баг өөрсдөө сонгоно.

Багийн баталгаажсан мэдүүлэгт багтсан 8 тамирчин тэмцээний хөтөлбөрийн дагуу жин үзүүлэх ба жин үзүүлсэн болохыг баталгаажуулж багаараа зогсоод фото зураг даруулна.

Баг тамирчид тэмцээнд ижил өнгийн бэлтгэлийн өмд, футболкоор жигдрэх бөгөөд энэхүү хувцастайгаа жиндээ орно.

Таталтад жин үзүүлээгүй тамирчныг оруулсан тохиолдолд тус багийг тухайн таталтад ялагдсанд тооцож, тэмцээнээс хасна.

Жинг 4 сарын 3-ний өдрийн 18:00 цагт Биеийн тамир, спортын газрын Хурлын танхимд үзнэ.

Тухайн баг (тамирчин шүүгчийн шийдвэрээр талбайг орхих, эрүүл мэндийн шалтгаанаар талбайд гарах боломжгүй байх) дутуу хүнтэй таталт гүйцэтгэх тохиолдолд 7 тамирчинтай тэмцээнийг гүйцэтгэж болох ба баг долоогоос бага хүнтэй оролцож болохгүй тул ялалтыг эсрэг багт өгнө.

Сагсан бөмбөг:

Сагсан бөмбөгийн төрөлд эрэгтэй 9 хүртэл, эмэгтэй 9 хүртэл тамирчинтай баг оролцоно. (Сагсан бөмбөгийн тэмцээн 2 ээлжээр, эрэгтэй 7 минут, эмэгтэй 5 минутаар бохир цагаар явагдана)

Зөвхөн шигшээ тоглолтууд сүүлийн 2 минут цэвэр цагаар явагдана.

Талбайд 35-45 насны 1 тамирчин, 46 ба түүнээс дээш насны 1 тамирчин заавал байна.

Сэлгээний тамирчдад мөн 35-45 насны 1 тамирчин, 46 ба түүнээс дээш насны 1 тамирчин заавал байх ба сэлгээний тамирчин нь сэлгэж байгаа тамирчинтай нэг насны ангиллын тамирчин байна.

Баг тамирчид 2 өнгийн, номертой, жигд өмсгөлтэй байна. Хоёр багийн өмсгөл ижил байгаа тохиолдолд Эзэн баг өмсгөлөө солино.

Багуудын тооноос хамаарч хэсэгт хувааж хэсгээс 2 баг гарч, хасагдах шатны тоглолтууд хийнэ.

Тэмцээний дүрэм, явагдах журмыг техникийн зөвлөгөөн дээр шүүгчдийн бүрэлдэхүүн тодорхой тайлбарлана.

Тэмцээний туршид үзүүлсэн үзүүлэлтээр "Шилдэг"-үүдийг шалгаруулна. Үүнд:

- "Шилдэг тэгш тоглогч"

- "Шилдэг холбон тоглогч"

- "Шилдэг хамгаалагч"

- "Шилдэг довтлогч" тус бүр эрэгтэй, эмэгтэй 1, 1 тамирчин шалгаруулна.

Волейбол:

Волейболын төрөлд эрэгтэй 10, эмэгтэй 10 тамирчинтай баг оролцоно. (тоглолт 3 ээлжээр 21 оноогоор явагдана)

Талбайд 35-45 насны 1 тамирчин, 46 ба түүнээс дээш насны 1 тамирчин заавал байна.

Сэлгээний тамирчдад мөн 35-45 насны 1 тамирчин, 46 ба түүнээс дээш насны 1 тамирчин заавал байх ба сэлгээний тамирчин нь сэлгэж байгаа тамирчинтай нэг насны ангиллын тамирчин байна.

Тэмцээний дүрэм, явагдах журмыг техникийн зөвлөгөөн дээр шүүгчдийн бүрэлдэхүүн тодорхой тайлбарлана.

Тэмцээний туршид үзүүлсэн үзүүлэлтээр “Шилдэг”-үүдийг шалгаруулна. Үүнд:

-“Шилдэг тэгш тоглогч”

-“Шилдэг холбон тоглогч”

-“Шилдэг хамгаалагч”

-“Шилдэг довтлогч” тус бүр эрэгтэй, эмэгтэй 1, 1 тамирчин шалгаруулна.

Тэмцээнд оролцох багийн тамирчид тухайн төрлийн зориулалтын тоглолтын хувцас өмссөн байна.

Дартс:

Дартсын тэмцээн багийн төрлөөр явагдана. Багт 2 эрэгтэй, 1 эмэгтэй тамирчин байна.

Тоглолт 501 онооноос хасаж тоглоно. Захаараа хожно. Багийн тоглогч нар ээлжлэн (1 дүгээр багийн эхний тоглогч 3 сум шидээд 2-р багийн эхний тоглогч 3 сум шидэх журмаар) 3, 3-н сум тавих ба 45 сум хүрсэн тохиолдолд бухын нүд рүү ойр шидсэн баг нь хожно. Зөвхөн бухын нүд рүү шидэхэд сум самбарт зоогдоогүй бол тухайн тамирчин дахин шиднэ.

Дартсын тэмцээн хасагдах журмаар явагдах ба эхэлж 2 хожсон баг нь дараагийн шатанд шалгарна.

Хагас шигшээ тоглолт түрүүлж 3 хожлоор, шигшээ тоглолт 4 хожлоор тус тус явагдана.

Хагас шигшээд 4 баг үлдэх ба хожсон 2 баг шигшээ тэмцээнд аваргын төлөө тоглолт хийж, хожигдсон 2 баг нь хүрэл медалийн болзол хангана.

Тоглолтын туршид хамгийн өндөр дундаж үзүүлсэн 1 багийг “Шилдэг баг”-аар шалгаруулна.

Дөрөв . Техникийн зөвлөгөөн, бүртгэл, баталгаажуулалт

Техникийн зөвлөгөөнийг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 16.00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимд хийнэ. Техникийн зөвлөгөөнд зөвхөн багийн ахлагч нар оролцох ба багууд тэмцээний спортын төрөл тус бүрд оролцох багуудын фото зургийг файл хэлбэрээр тамга тэмдэг бүхий мэдүүлгийн хамт 2024 оны 03 дугаар сарын 15-ны дотор doljoo.0201@gmail.com хаягаар илгээсэн байна.

Мэдүүлэгт орсон тамирчдыг аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс 2024 оны 03 дугаар сарын 22-ны дотор шалган баталгаажуулна.

Спортын наадамд мэдүүлэгт баталгаажаагүй болон шаардлага хангаагүй, зөрчилтэй тамирчин оруулсан, удирдамж зөрчсөн багийг тухайн тэмцээнээс хасна.

Тав. Шагнал урамшуулал, багийн оноо гаргах журам

Тэмцээний төрөл тус бүрд:

1 дүгээр байр эзэлсэн баг тамирчдыг алтан медаль, өргөмжлөл 1.000.000 төгрөг,

2 дугаар байр эзэлсэн баг тамирчдыг мөнгөн медаль, өргөмжлөл 800.000 төгрөг,

3 дугаар байр эзэлсэн баг тамирчдыг хүрэл медаль, өргөмжлөл 600.000 төгрөгөөр тус тус шагнаж урамшуулна.

Спортын төрлүүдийн нийлбэр дүнгээр эхний 5 байр эзлүүлж:

- 1 дүгээр байр цом, өргөмжлөл, 3.000.000 төгрөг,
- 2 дугаар байр өргөмжлөл 2.000.000 төгрөг,
- 3 дугаар байр өргөмжлөл 1.500.000 төгрөг,
- 4 дугаар байр өргөмжлөл 1.000.000 төгрөг,
- 5 дугаар байр өргөмжлөл 800.000 төгрөгөөр шагнаж урамшуулна.

Мөн тэмцээний шигшээ тоглолтуудад багаар ажиллах чадвар, эв нэгдлийг эрхэмлэн нэгдсэн зохион байгуулалттайгаар баг тамирчдаа дэмжиж, тэмцээнд онцлог өнгө төрхийг нэмж, эерэг уур амьсгал бүрдүүлсэн **“ШИЛДЭГ ХӨГЖӨӨН ДЭМЖИГЧ”** 3 багийг шалгаруулж

- 1 дүгээр байр өргөмжлөл 500.000 төгрөг,
- 2 дугаар байр өргөмжлөл 400.000 төгрөг,
- 3 дугаар байр өргөмжлөл 300.000 төгрөгөөр шагнаж урамшуулна.

Багийн дүнг төрөл тус бүрийн амжилтаар жагсаан бага онооны системээр дүгнэнэ. (Алтан медаль-1 оноо, мөнгөн медаль-3 оноо, хүрэл медаль-5 оноо, 4 дүгээр байраас 7 оноогоор эхлэн байр ухрах бүрд +1 оноогоор нэмэгдэж бодогдоно)

Багийн дүнгээр оноо тэнцсэн тохиолдолд тухайн оноо тэнцсэн багуудын сагсан бөмбөг болон волейболын төрлүүдийн эмэгтэй багийн амжилтаар байр эзлүүлнэ.

Спортын аль нэг төрөлд ороогүй багийн тухайн төрөлд багийн онооны хамгийн их оноог өгнө.

Баг удирдамж зөрчиж хасагдсан тохиолдолд мөн тухайн төрөлд багийн онооны хамгийн их оноог өгнө.

ХЯНАСАН:

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА  Ж.ГАНТУЛГА

БОЛОВСРУУЛСАН:

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
АЛБАНЫ ДАРГА  Г.СОЛОНГО

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ
СПОРТЫН ТЭМЦЭЭНД БАГ БҮРДҮҮЛЖ ОРОЛЦОХ
АГЕНТЛАГ БАЙГУУЛЛАГУУДЫН ХУВААРЬ**

| Д/д | Агентлаг, байгууллагын нэр | Багийн тоо |
|------------|--|-------------------|
| 1 | Аймгийн ИТХ-ын ажлын алба | 1 |
| 2 | Аймгийн ЗДТГ | |
| 3 | Аймаг дахь Төрийн аудитын газар | |
| 4 | Орон нутгийн өмчийн газар | |
| 5 | Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба | |
| 6 | Статистикийн хэлтэс | |
| 7 | Цахим хөгжлийн хэлтэс | |
| 8 | Байгаль орчин, аялал жуулчлалын газар | 1 |
| 9 | Ус, цаг уур, орчны шинжилгээний төв | |
| 10 | Хэрлэн голын сав газрын захиргаа | 1 |
| 11 | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | |
| 12 | Стандарт, хэмжил зүйн хэлтэс | |
| 13 | Нисэх буудал | 1 |
| 14 | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар | |
| 15 | Татварын газар | |
| 16 | Нийгмийн даатгалын газар | 1 |
| 17 | Онцгой байдлын газар | |
| 18 | Улсын бүртгэлийн хэлтэс | 1 |
| 19 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар | |
| 20 | Авто тээврийн төв | |
| 21 | Хүнс, хөдөө аж ахуйн газар | 1 |
| 22 | Мал эмнэлгийн газар | |
| 23 | Цагдаагийн газар | 1 |
| 24 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар | 1 |
| 25 | Эрүүл мэндийн газар | 1 |
| 26 | ЗӨСТөв | |
| 27 | Эрүүл мэндийн даатгалын хэлтэс | |
| 28 | Нэгдсэн эмнэлэг | |
| 30 | Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг | |
| 31 | Аймгийн Шүүх | 1 |
| 32 | Аймгийн Прокурорын газар | |
| 33 | Тагнуулын хэлтэс | |
| 34 | Шүүх шинжилгээний хэлтэс | |
| 35 | Боловсрол шинжлэх ухааны газар | 1 |
| 36 | Насан туршийн боловсролын төв | |
| 37 | Соёл, урлагийн газар | |
| 38 | Номын сангийн | |
| 39 | Музей | |
| 40 | Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулга | |

| | | |
|-------------|------------------------------|-----------|
| 41 | Харгуй ТӨХК | 1 |
| 42 | Мэдээлэл Холбооны сүлжээ ТӨК | 1 |
| 43 | Цахилгаан Холбооны газар | |
| 44 | Шуудан үйлчилгээний газар | |
| 45 | БЗӨБЦТСС | 1 |
| 46 | ЦТС | 1 |
| 47 | Хэнтий-Ус ХХК | |
| 48 | ПТК | 1 |
| Нийт | | 17 |